НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/013/НА-СТА-ЗГТС

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын алба Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Цолмон<br>Утас: 325093 Цахим хаяг: Tsolmonba@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 198

танай ____________-ны № ____________-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА О.ПҮРЭВЖАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 4,024.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд 1,539.1 сая төгрөг буюу 38.2 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагын 9 хувь нь нас барсан иргэдийн, 50.3 хувь нь шүүх ажиллагаанд, 30.3 хувь нь эвлэрлийн хугацаанд, 10.3 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж авлага барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2025 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулан нийт 1,183.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 101 иргэнтэй, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх 83.7 сая төгрөгийн сургалтын зардлыг 9 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зарцуулсан байна.

1426050117

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь, болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,438,575,179.80** | **4,026,943,198.80** |
| **33** | **АВЛАГА** | 4,438,575,179.80 | 4,026,943,198.80 |
| **335** | **Бусад авлага** | 4,438,575,179.80 | 4,026,943,198.80 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 31,708,760.00 | 2,048,760.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,406,866,419.80 | 4,024,894,438.80 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,438,575,179.80** | **4,026,943,198.80** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **370,429,404.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 370,429,404.00 |
| **413** | **Өглөг** | - | 370,429,404.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 370,429,404.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 81,419,404.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 289,010,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,438,575,179.80** | **3,656,513,794.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,438,575,179.80 | 3,656,513,794.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,438,575,179.80 | 3,656,953,794.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,244,649,381.80 | 4,438,575,179.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 193,925,798.00 | (781,621,385.00) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,438,575,179.80** | **4,026,943,198.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,950,779,300.00** | **1,913,546,840.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,434,000.00** | **1,913,546,840.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 46,434,000.00 | 1,913,546,840.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 45,210,000.00 | 1,913,546,840.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | - | 92,398,126.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,210,000.00 | 49,412,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 1,771,736,714.00 |
| 120009 | Бусад орлого | 1,224,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,904,345,300.00** | **1,864,134,840.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,904,345,300.00 | 1,864,134,840.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 3,904,345,300.00 | 1,864,134,840.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,756,853,502.00** | **2,695,168,225.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,756,853,502.00** | **2,695,168,225.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 63,264,250.00 | 36,625,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,264,250.00 | 36,625,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,264,250.00 | 36,625,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,693,589,252.00 | 2,658,543,225.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 778,680,900.00 | 764,814,180.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 778,680,900.00 | 764,814,180.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,210,000.00 | 16,412,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,210,000.00 | 16,412,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,855,435,940.00 | 1,013,062,154.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,855,435,940.00 | 1,013,062,154.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,014,262,412.00 | 864,254,891.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,014,262,412.00 | 864,254,891.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **193,925,798.00** | **(781,621,385.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **193,925,798.00** | **(781,621,385.00)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,289,251,090.00** | **1,913,823,930.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **384,905,790.00** | **49,689,090.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **384,905,790.00** | **49,689,090.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **383,681,790.00** | **49,412,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | - | 92,398,126.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,210,000.00 | 49,412,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 338,471,790.00 | 1,771,736,714.00 - |
| 120009 | Бусад орлого | 1,224,000.00 | 277,090.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,904,345,300.00** | **1,864,134,840.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,904,345,300.00 | 1,864,134,840.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 3,904,345,300.00 | 1,864,134,840.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **5,303,513,502.00** | **3,478,078,821.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,303,513,502.00** | **3,478,078,821.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **63,064,250.00** | **31,365,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,064,250.00 | 31,365,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,064,250.00 | 31,365,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,240,449,252.00** | **3,446,713,821.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,325,540,900.00 | 1,552,984,776.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,325,540,900.00 | 1,552,984,776.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,210,000.00 | 16,412,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,210,000.00 | 16,412,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,855,435,940.00 | 1,013,062,154.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,855,435,940.00 | 1,013,062,154.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,014,262,412.00 | 864,254,891.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,014,262,412.00 | 864,254,891.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** (3)=(1)-(2) | **(1,014,262,412.00)** | **(1,564,254,891.00)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 1,014,262,412.00 | 1,564,254,891.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 1,014,262,412.00 | 1,564,254,891.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,014,262,412.00** | **1,564,254,891.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | 4,438,575,179.80 | 4,438,575,179.80 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | 4,438,575,179.80 | 4,438,575,179.80 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 4,438,575,179.80 | 4,438,575,179.80 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | 4,438,135,179.80 | 4,438,135,179.80 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (781,621,385.00) | (781,621,385.00) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 3,656,513,794.80 | 3,656,513,794.80 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,637,134,840.00 | 1,584,349,776.00 | 1,052,785,064.00 | 60.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,637,134,840.00 | 1,584,349,776.00 | 1,052,785,064.00 | 60.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 69,750,000.00 | 31,365,000.00 | 38,385,000.00 | 45.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 69,750,000.00 | 31,365,000.00 | 38,385,000.00 | 45.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 69,750,000.00 | 31,365,000.00 | 38,385,000.00 | 45.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,567,384,840.00 | 1,552,984,776.00 | 1,014,400,064.00 | 60.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,567,384,840.00 | 1,552,984,776.00 | 1,014,400,064.00 | 60.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,567,384,840.00 | 1,552,984,776.00 | 1,014,400,064.00 | 60.5 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,904,134,840.00 | 1,864,134,800.00 | 40,000,040.00 | 97.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,904,134,840.00 | 1,864,134,800.00 | 40,000,040.00 | 97.9 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,771,736,714.00 | 1,771,736,714.00 | - | 100.0 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 132,398,126.00 | 92,398,126 .00 | 40,000,040.00 | 97.9 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | | | | |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,940.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 2,940.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлд

## ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нас барсан 50 иргэдийн авлагад эрсдэлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс 2,940.0 мянган төгрөг гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу төлөгдөөгүй байна. | 1 | 2,940.0 | | | | | 1 | 2,940.0 | | | | |
| **Дүн** | **2** | **2,940.0** | | | | | **2** | **2,940.0** | - | - | | |